*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

## БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ЭРХЭМБАЯР ОВОГТОЙ МӨНХЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах** | | | | | | | |
| 1. | Хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ | Хэрэгжилт, хувиар, гүйцэтгэлээр | - | 1. Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр гарсан бодлогын баримт бичиг, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, бараагаа өөрөө мэдүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх, санал боловсруулан танилцуулсан байна. | - Тайлант хугацаанд цахимаар өөрөө мэдүүлсэн 627 гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтын хяналтыг хийж, цахимаар өөрөө мэдүүлж буй иргэн, ААН-үүдэд гаалийн холбогдох хууль тогтоомж болон мэдүүлгийн алдааны талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.<br>- Хариуцсан ажлын хүрээнд хөнгөлөлттэй тарифаар мэдүүлж буй гаалийн бүрдүүлэлтийн мэдээг хянах явцад цахимаар өөрөө мэдүүлж буй иргэн, ААН-үүд нь Япон-Монголын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр болон Ази-Номхон далайн худалдааны хэлэлцээрийн гарал үүслийн гэрчилгээ байхгүй, тус хэлэлцээрт хамаарахгүй барааг андуурч хөнгөлөлттэй тарифаар илгээсэн байсан 23 мэдүүлгийн жагсаалтыг гаргаж хариуцсан ГУАБ-д өгч, мэдүүлгийн алдааг зассан. | 2024.01.01-2024.12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа | - Гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтын хяналтыг хэрэгжүүлж ажиллахдаа гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ГБМ-ээс шалтгаалах мэдүүлгийн алдааг тухай бүр засуулж ажилласан.<br>- Тайлант хугацаанд 1367 удаагийн засварт буцаалтаар 1169 мэдүүлгийг засварт буцаснаас хамгийн их утга нь Барааны нэр, марк, зориулалт, Барааны код /Унификаци/-тай холбоотой 403 буцаалт,<br>Нэгж үнэ, тоо хэмжээ, цэвэр бохир жин, даатгал, тээврийн зардалтай холбоотой 199 буцаалт байна.<br>- УБ транс ХХК-ийн Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нь 2024.03.27-ний өдөр 03-2091008-24-I31084 сүлжээ дугаараар Металл-Опт ХХК-ийн гаальд мэдүүлсэн барааны гарал үүсэл дээрх БТКУС кодыг буруу мэдүүлсэн тул зөрчил гаргасан тул харьяаллын дагуу Замын-үүд ГГ-ийн зөрчил хариуцсан ГУБ-д шилжүүлж ЗШШТХ-ийн 11.21.14-дэх хэсгийг үндэслэн торгуулийн арга хэмжээ авсан. | 2024.01.01-2024.12.10 | 90 |
| 3. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын БАҮХ-т томилогдож барааны БТКУС-ын код тодорхойлох ажлын хэсэгт орж ажиллах | - 2024.02.23-аас 03.18-ний өдөр хүртэлх хугацаанд ГЕГ-ийн БАҮХ-т томилогдож ажилласан. Ажиллах хугацаанд Засгийн газрын 2024.01.25-ны өдрийн 37-р тогтоолоор Цэнгазар ХХК-ийн Говь-Алтай аймгийн Тайшир сумын дөрвөлжин шохойн чулууны ордыг түшиглэн байгуулах шохойн үйлдвэрийн бүтээн байгуулалтад зориулагдан импортоор оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж | 2024.01.01-2024.12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх ажлын хүрээнд тус компанийн БНХАУ-аас нийлүүлэх нийт 7 үнийн нэхэмжлэхийн 78 бараа, болон задаргаа 506 барааны кодыг тодорхойлох ажлын хэсэгт орж ажилласан. | | |
| 4. | Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Нэгжийн чиг үүргийн хүрээнд төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Авилгын эсрэг төлөвлөөний хүрээнд ГЕГ-ын Хуулийн хэлтсээс 2024.06.04-ны өдөр зохион байгуулсан танхимын сургалтанд хамрагдсан. | 2024.01.01-2024.12.10 | 90 |
| **Зорилт 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх** | | | | | | | |
| 1. | Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалт хийсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Бичиг баримтын бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангаж, бичиг баримтын шалгалтыг горимын шаардлага, хууль тогтоомжийн хүрээнд бүрэн алдаагүй хийж, зохих төлөвт бүрэн байршуулсан байна. | - Тайлант хугацаанд импортын нийт 7053 гаалийн мэдүүлгээр 232.8 сая ам долларын үнийн дүн бүхий 33225 барааны бүрдүүлэлт хийж 110.3 тэрбум төгрөгийн татвар, 63.9 сая төгрөгийн хураамж, экспортын нийт 81 мэдүүлгээр 24.8 сая ам долларын 143 барааны бүрдүүлэлт хийж 5.4 сая төгрөгийн хураамж тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн /Кайс системийн ББГУБ тайлан цэснээс татсан мэдээ/.<br>- 2024.12.10-ны өдрийн байлаар кайс системийн импортын бичиг баримтын шалгалт цэснээс бичиг баримтын шалгалт хийсэн мэдүүлгийг төлөвөөр нь нягталж үзэхэд: Гааль зөвшөөрөв төлөвт оруулсан 7077 мэдүүлэг, бичиг баримтын шалгалт хийсэн-9 мэдүүлэг, засварт буцаасан-7 мэдүүлэг, татгалзсан-14 мэдүүлэг байгаа бөгөөд ББГУБ-руу буцаасан, | 2024.01.01-2024.12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ГЕГ-аас засварт буцаасан болон ГЕГ-т хүсэлт илгээсэн мэдүүлэг байхгүй байна.<br>- Тайлант хугацаанд импортын нийт 33224 барааны гаалийн үнийг хянаж бичиг баримтын шалгалт хийснээс 74.5 хувийг хэлцлийн үнийн аргаар үнэлсэн.<br>- Уялдуулан хэрэглэх үнийн арга буюу 6-р аргаар нийт 8532 барааны гаалийн нэгж үнийг дахин тодорхойлж 9.4 сая ам доллар буюу нийт 5.01 тэрбум төгрөгийн татварыг нэмж улсын төсөвт төвлөрүүлсэн. | | |
| 2. | Гаалийн бүрдүүлэлтэд гарсан алдаа болон зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт, алдааг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил | Илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татварын дүн, торгуулийн дүн | - | Бичиг баримтын шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татвар, торгуулийн дүнг өмнөх оны мөн үеэс 2 хүртэл хувиар нэмэгдүүлнэ. | - УБ транс ХХК-ийн Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нь 2024.03.27-ний өдөр 03-2091008-24-I31084 сүлжээ дугаараар Металл-Опт ХХК-ийн гаальд мэдүүлсэн Арматур төмөр барааны гарал үүсэл дээрх БТКУС кодыг буруу мэдүүлсэн зөрчил гаргасан тул харьяаллын дагуу Замын-үүд ГГ-ийн зөрчил хариуцсан ГУБ-д шилжүүлж ЗШШТХ-ийн 11.21.14-дэх хэсгийг үндэслэн торгуулийн арга хэмжээ авсан.<br>- 2024.01.09-ний өдөр иргэн Содномдоржийн Шихихутаг Mercedes-Benz, G550 маркийн автомашиныг анх гаальд мэдүүлэхдээ дуудлага худалдааны баримтыг хавсаргаагүй зөрчил гаргасан тул харьяаллын дагуу УБГГ-ын зөрчлийн албанд шилжүүлж ЗШШТХ-ийн 11.21.12-дахь заалтыг үндэслэн торгуулийн арга хэмжээ авсан болно. | 2024.01.01-2024.12.10 | 90 |
| 3. | | | - | Гаалийн бүрдүүлэлтийн | - Тайлант хугацаанд гаалийн бүрдүүлэлтийн горимын | 2024.01.01-2024.12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт, гаалийн тариф, гарал үүслийн хяналт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | горимын хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. | хэрэгжилтийг хангуулж ажиллан импортын нийт 31 төрлийн горимоор 7073 гаалийн бүрдүүлэлт, экспортын нийт 3 төрлийн горимоор 81 бүрдүүлэлт хийсэн байна. Нийт импортын бүрдүүлэлтийн 89.3 хувийг 400 горимын бүрдүүлэлт эзэлж байна.<br>- Гаалийн мэдүүлгийг шалгах, бичиг баримтын шалгалт хийхдээ Япон-Монголын эдийн засгийн хэлэлцээр болон Ази-Номхон далайн худалдааны хэлэлцээрийн дагуу хөнгөлөлттэй тарифаар мэдүүлж буй барааны гарал үүслийн гэрчилгээг нягтлан шалгаж, хэлэлцээрийг хэрэгжүүлж ажилласан.<br>- БЦТ-ийн үйл ажиллагааны хүрээнд гаалийн тариф, гарал үүсэл хариуцан ажиллаж байгаа бөгөөд хариуцсан ажлын хүрээнд Япон-Монголын эдийн засгийн хэлэлцээр болон Ази-Номхон далайн худалдааны хэлэлцээр /АПТА/-ийн хөнгөлөлттэй тарифаар хийсэн гаалийн бүрдүүлэлтийн мэдээг тухай бүр нягтлан шалгаж алдаатай мэдүүлгийн мэдээллийг хариуцсан ГУАБ-д мэдэгдэж тухай бүр алдааг засуулж ажилласан. Мөн БЦТ-ийн тариф, гарал үүслийн мэдээ, тайланг тухай бүр гаргаж ажилласан.<br>БЦТ-ийн нийт ГУБ нарт зориулж гарал үүслийн гэрчилгээг хэрхэн шалгах заавар бүхий PPD файлыг бэлтгэн танилцуулсан.<br>- 2024.02.01-нд Аринакомпьютерс ХХК-ийн 03-0914235-24-I00012 сүлжээ Ухаалаг дэлгэц, сурталчилгааны гэх барааг БТКУС- | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ийн 8471.41.00-кодоор /гаалийн тариф 0 хувь/ мэдүүлснийг барааны онцлог шинж, үзүүлэлт, зориулалт зэргийг нягтлан шалгаж үзэхэд тус кодод хамаарахгүй бараа болох нь тогтоогдсон тул барааны кодыг 8528.52.00 /гаалийн тариф 5 хувь/ кодоор засаж мэдүүлсэн.<br>- 2024.07.02-ний I37145 дугаартай Хан алтай ресурс ХХК-ийн мэдүүлсэн 3 нэр төрлийн барааны гарал үүслийг нотлох баримт хангалтгүй тул ердийн тарифт шилжүүлж 3.9 сая төгрөг,<br>- 2024.07.08-ний I00009 дугаартай Чип электроникс ХХК-ийн барааны гарал үүслийг нотлох баримт хангалтгүй тул ердийн тарифт шилжүүлж 2.8 сая төгрөгийг тус тус нэмж төлүүлсэн. | | |
| 4. | Барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх, тодорхойлох чиглэлээр зохион байгуулсан ажил | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Гаалийн үнийн хяналтыг цахимжуулах боломжийг судалж эхэлсэн байна. | - Гаалийн үнийн хяналтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд БТКУС-н 8703-д хамаарах солонгос суудлын автомашины үнийн судалгаа мөн 8705-д хамаарах бетон зуурагч, 6810-д хамаарах цементэн хавтан, 6904-д хамаарах тоосго зэрэг зарим нэрийн барааны судалгааны үнийг баримтлан, үнийн нэгдмэл байдлыг хангаж ажилласан.<br>- Хариуцсан бүлгийн хүрээнд БТКУС-ийн 9018-р бүлэгт хамаарах барааны ангиллын код, бичлэгийг ГУАБ-ийн хамт нягтлан шалгаж тухай бүр алдаатай мэдүүлгийг засуулж байсан. Мөн хариуцсан бүлгийн /90-р бүлэг/ барааны ангиллын кодыг зөв тодорхойлох талаар PDF танилцуулга бэлдэж ГУБ нарт танилцуулсан. | 2024.01.01-2024.12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - БТКУС-ийн гомдол маргаан шийдвэрлэх ажлын хүрээнд Чоногол трейд ХХК-ийн БТКУС-ийн 9018-кодоор мэдүүлсэн бараанд хамаарах БТКУС-ийн код тодорхойлуулах гомдлыг нягтлан шалгаж БТКУС-ийн 9021-д хамаарах бараа болохыг тодорхойлсон шийдвэр гаргаж ГЕГ-ын БАҮХ-ээс тус шийдвэрийг хэвээр үлдээсэн тул уг ААН-ийн мэдүүлсэн барааны кодыг БТКУС-ийн 9021 /гаалийн тариф 5 хувьтай/ кодоор засаж мэдүүлсэн.<br>- Бичиг баримтын шалгалтын явцад барааны ангилал, унификаци, зориулалт, онцлог шинжийг нягтлан шалгаж 403 удаагийн засварт буцаалтаар мэдүүлгийг засуулсан байна. | | |
| **Зорилт 4: "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"** | | | | | | | |
| 1. | Өргөдөл, гомдол, маргааныг шийдвэрлэсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Бичиг баримтын бүрдүүлэлтийн үе шатанд ирсэн өргөдөл, гомдолыг холбогдох хуульд заасан хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн байна. | 2024 оны 01, 04, 09 дүгээр сарuудад барааны ангилал, гомдол маргаан хүлээн авах шийдвэрлэх хэсэгт хуваарийн дагуу ажилласан.<br>2024 оны 01 сард ажиллахдаа барааны ангилал, үнэ үнэлгээтэй холбоотой 14 аж ахуй нэгжийн гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, хариуг хүргүүлж ажилласан. Үүнээс ГУБ-ийн шийдвэрийг хэвээр үлдээсэн 5 шийдвэр, барааны үнийг дахин хянах 9 шийдвэрийг тус тус гаргасан байна. 2024 оны 04 дүгээр сард ажиллахдаа Гомдол, мэдээлэл хүлээн авах 7000-1280 дугаарын утсыг хариуцан ажиллаж давхардсан тоогоор 1314 дуудлага хүлээн авч, 1264 дуудлага бүртгэж ажиласан. | 2024.01.01-2024.12.10 | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2024 оны 09 сард ажиллахдаа барааны ангилал, үнэ үнэлгээтэй холбоотой 9 аж ахуй нэгжийн гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, хариуг хүргүүлж ажилласан байна. | | |
| 2. | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Гаалийн хяналт бүрдүүлэлттэй холбоотой хууль тогтоомж, журам, зааврыг боловсронгуй болгоход санал санаачлагатай ажилласан байна. | Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн гаалийн хяналт бүрдүүлэлттэй холбоотой хууль, журам зааврыг боловсронгуй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах журмын төслүүдэд тухай бүр хариуцсан багаар санал өгч, холбогдох удирдлагуудад хүргүүлж ажилласан. “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”, “ГУБ-д цол олгон, хураах, сэргээх, цолны нэмэгдэл хөлс олгох журам”, “ГУБ-ийн үйлчилгээний стандартын журам”, “ГУБ-ий сахилгын дүрэм”, “ГУБ-ийн ёс зүйн дүрэм” зэрэг хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой холбогдох саналуудыг өгсөн. | 2024.01.01-2024.12.10 | 90 |
| 3. | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.ГЕГ-ын удирдлага, Захиргааны зөвлөл, мэргэжлийн зөвлөл, шуурхай хуралдаанаас өгсөн зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаварыг хэрэгжүүлж, биелэлтийг хугацаанд нь гаргаж тайлагнасан байна. | ГЕГ-ын удирдлага, БЦТ-ийн удирдлага болон ГЕГ-ийн холбогдох алба хэлтэсүүд, шуурхай хуралдаанаас өгсөн зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаварыг тухай бүр хэрэгжүүлж, биелэлтийг хугацаанд нь тайлагнаж ажилласан. | 2024.01.01-2024.12.10 | 90 |
| 4. | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Ажлын цаг ашиглалт 90 хувиас доошгүй байна. | Тайлант хугацаанд өвчтэй, чөлөөтэй, тасалсан цаг байхгүй болно.<br>2024 оны ээлжийн амралтыг 10 сарын 12-ны өдрөөс ажлын 20 хоног биеэр эдэлсэн. | 2024.01.01-2024.12.10 | 95 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | 70001280 утсаар болон www.tsakhimgaali@customs.gov.mn цахим хаягийн бүртгэлд хяналт тавих | | | 7000-1280 утасны бүртгэлд хяналт тавих, гомдол хүсэлтийг програмд бүртгэж, хаалт хийсэн байна. | 2024.04.08-аас 2024.04.30 хүртэлх хугацаанд 7000-1280 утасны гомдол, мэдээлэл бүртгэх ажлыг хариуцан ажиллахдаа нийт давхардсан тоогоор 1314 дуудлага ирснээс 1264 гомдол хүсэлтийг шивж бүртгэсэн байна. Бүрдүүлэлт удаад байна, үнэлгээ өндөр гарсан байна, ГУБ сольж өгнө үү, мэдүүлэг буцааж өгнө үү гэх мэтээр ирсэн дуудлага бүрийг тухай бүр бүртгэн холбогдох ГУАБ болон ГУБ нарт мэдээллийг хурдан шуурхай өгч, асуудлыг шийдвэрлүүлж ажилласан байна. Мөн гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа, хууль журамтай холбоотой 160 дуудлагыг бүртгэж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | 2024.01.01-2024.12.10 | 90 |
| 2. | Үнийн мэдээллийн санг бүрдүүлж, ажиллах чиглэлээр | | | БТКУС-ийн хариуцсан бүлгийн үнийн мэдээллийн санг баяжуулж ажилласан байна. | 2024 оны 01 дүгээр сард барааны ангилал, гомдол маргаан хариуцан ажиллах хугацаанд 21-ээс 29-р бүлгийн үнийн мэдээллийн санг баяжуулах чиглэлээр 165340 барааны бичлэгийг хянаж үнийн мэдээллийн санд илгээсэн. Алдаатай 10 барааны бичлэгийг нягтлан шалгах шаардлатай жагсаалтад хянаж, оруулсан.<br>Хариуцсан бүлгийн хүрээнд 2024.01.01-ээс 2024.11.30 хүртэлх хугацаанд БТКУС-ийн 9018-аас 9033 хүртэлх 16 бүлэг барааны | 2024.01.01-2024.12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нийт 29320 барааны бичлэгийг хянаж хэлцлийн үнийн баазад оруулах, 719 барааны бичлэгийг нягтлан шалгах саналтай үнийн мэдээллийн санд илгээсэн байна. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Гадаад дотоод болон ажлын байранд зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлэх | | | Сургалтад бүрэн хамрагдсан байна. | - 2024.01.16-ны өдөр ГЕГ-ын БАҮХ-ээс зохион байгуулсан БТКУС-ийн кодын анхаарах асуудлууд сэдэвт сургалт<br>- 2024.05.02-ны өдөр ГЕГ-ын БАҮХ-ээс үнэ, үнэлгээний чиглэлээр зохион байгуулсан танхимын сургалт<br>- 2024.05.06-нд МҮХАҮ-ийн танхимд Монгол улсад гадаад худалдааг хөгжүүлэх төслийн хүрээнд зохион байгуулсан “Экспортын хөнгөлөлтийн систем, гарал үүсэл” сэдэвт сургалт<br>- 2024.06.04-ний өдөр ГЕГ-аас зохион байгуулсан Эрүүгийн хууль, авилгын гэмт хэрэг сэдэвт сургалт<br>- 2024.06.11-ний өдөр БЦТ-д ШУТИС-ийн багш Ц.Мөнхтуяа Металл, материал судлал сэдэвт сургалт<br>- 2024.07.18 БЦТ-д С.Норжинсүрэн багш Инкотермес сэдэвт сургалт<br>2024.07.05-ний өдөр БЦТ-д Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд гарч буй алдаа сэдэвт сургалт. Прокурор Гансувд<br>- 2024.08.06-ний өдөр БЦТ-д ГХБГ-ийн ГУАБ Ариунцэцэг Галт зэвсгийн тухай хууль сэдэвт сургалт | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - 2024.09.19-ний өдөр Озоны үндэсний албанаас хийсэн сургалт<br>- ГЕГ-ын ЭУХ-ээс зохион байгуулсан “Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэх онол, практикийн асуудал” сэдэвт сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан.<br>- 2024.11.02-ний өдөр БЦТ-д ГТЛ-ийн дарга Цэрэнчимэд Бараанаас сорьц дээж авах тухай сургалт<br>- 2024.11.13-аас 2024.11.15 хүртэлх хугацаанд ГЕГ-Гаалийн үнэлгээний ахисан түвшний сургалтанд хамрагдаж сертификат авсан.<br>- БЦТ-өөс дотооддоо зохион байгуулсан бүх сургалт, мэдээллийн цаг бүрэн хамрагдсан. | | |
| 2. | Үйл ажиллагаатай холбоотойгоор холбогдох шинээр гарсан хууль, тогтоомж, тогтоол, журам, зааврыг тухай бүр уншиж судлан, хууль эрх зүйн мэдлэгээ сайжруулах | | | Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн байна | Гаалийн хяналт бүрдүүлэлтийн үйл ажиллагаатай холбоотойгоор шинээр гарсан хууль, тогтоомж, тогтоол, журам, зааврыг тухай бүр уншиж судлан танилцаж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэн өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна. | 2024.01.01-2024.12.10 | 90 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Гаалийн улсын байцаагч — Э.Мөнхцэцэг / ........................... / — 2024 он 12 сарын 10 өдөр

*( Албан тушаал )* — *( Нэр, гарын үсэг )* — *( Огноо )*

1827

# БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ЭРХЭМБАЯР ОВОГТОЙ МӨНХЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Бүрдүүлэлтийн цахим төв

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалахийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ | 50 | 10 | 60 | |
| 2. | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа | 50 | 10 | 60 | |
| 3. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 50 | 10 | 60 | |
| 4. | Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | 50 | 10 | 60 | |
| **Зорилт 2. Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэхийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалт хийсэн байдал | 50 | 10 | 60 | |
| 2. | Гаалийн бүрдүүлэлтэд гарсан алдаа болон зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт, алдааг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил | 50 | 10 | 60 | |
| 3. | Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт, гаалийн тариф, гарал үүслийн хяналт | 50 | 10 | 60 | |
| 4. | Барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх, тодорхойлох чиглэлээр зохион байгуулсан ажил | 50 | 10 | 60 | |
| **Зорилт 4. Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэхийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Өргөдөл, гомдол, маргааныг шийдвэрлэсэн байдал | 50 | 10 | 60 | |
| 2. | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | 50 | 10 | 60 | |
| 3. | Үүрэг даалгаврын биелэлт | 50 | 10 | 60 | |
| 4. | Ажлын цаг ашиглалт | 50 | 10 | 60 | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1. | 70001280 утсаар болон www.tsakhimgaali@customs.gov.mn цахим хаягийн бүртгэлд хяналт тавих | 50 | 10 | 60 | |
| | Үнийн мэдээллийн санг бүрдүүлж, ажиллах чиглэлээр | 50 | 10 | 60 | |
| **Дундаж оноо:** | | | | 60 | |

2. **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Гадаад дотоод болон ажлын байранд зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлэх | 100% | 15 | |
| 2. | Үйл ажиллагаатай холбоотойгоор холбогдох шинээр гарсан хууль, тогтоомж, тогтоол, журам, зааврыг тухай бүр уншиж судлан, хууль эрх зүйн мэдлэгээ сайжруулах | 100% | 15 | |
| **Дундаж оноо** | | | 15 | |

### 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | 7 | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | 7 | |
| **Дундаж оноо** | | 7 | |

### 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо** | | 8 |

### 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | 60 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | 7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | – |
| **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 90.0 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Бүрдүүлэлтийн цахим төвийн дарга ........................ /Э.Лхагвасүрэн/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.10 (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Гаалийн улсын байцаагч ........................ /Э.Мөнхцэцэг/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.10 (огноо)

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

ГЕГ-ын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................ /Г.Энхтайван/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

XII/20, 2024 (огноо)

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

ГЕГ-ын Хүний нөөцийн хэлтсийн Гаалийн улсын ахлах байцаагч ........................ /Ө.Тэгшээ/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.20 (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

ГЕГ-ын дарга ........................ /Р.Отгонжаргал/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.20 (огноо)